

НОМЫН ШҮҮМЖ

ХЯТАД ДАХЬ ҮНДЭСТНИЙ АСУУДЛЫН ТУХАЙ

(Шүүмж)

Зөвлөлтийн хятад судлаач эрдэмтэд В. А. Богословский А. А. Москалев нарын туурвисан «Хятад дахь үндэстний асуудал» (1911—1949)* хэмээх ном нь Хятад хятад биш ард түмнүүдийн 1911 оноос 1949 оны 100-р сар хүртэлх үеийн түүхийг шинжлэн судлахад зориулагджээ. Энэ үе бол хятад биш ард түмнүүдийн хувьд их Хятадын дээрэнгүй үзлийн эсрэг хийсэн хурц ширүүн тэмцэл, тэдний үндэстний эрх чөлөөний хөдөлгөөний ерөнхий өсөлтийн жилүүд байсан юм. Мөн энэ үе нь «ардын гурван зарчим»-ын тухай сургаалыг бүтээгч Сунь Ятсен нэгдмэл, хүчирхэг тусгаар тогтносон Хятад улсыг байгуулахыг уриалж байсан үе билээ. Тэрчлэн Хятадад гоминданы ноёрхол тогтож, Хятад үндэстнийг шүтээн болгон хэт өргөмжилж хятад биш ард түмнүүдийг түргэн зуур уусган хятадчилах санаа бүхий Чан Кайшигийнхний үндэстний номлол бүрэлдэн бий болж, түүнийг практикт хэрэгжүүлж байсан үе бөгөөд эцэст энэ номлол нь бүрэн сүйрэн унасан билээ. Мөн энэ жилүүдэд Хятадын коммунистууд үндэстний асуудлыг шийдвэрлэх талаар зарчмын өөр чиг шугам баримтлан, үндэстнүүдийн өөртөө засан тохинох эрхийг хангах тухай марксист—ленинист шаардлагыг дэмжиж, ХКН-аар удирдуулсан тус орны ард түмний хувьсгалт тэмцэлд хятад биш ард түмнүүдийг татан оролцуулах талаар дэмжлэг үзүүлж байсан үе байлаа гэдгийг зохиогчид номын оршилдоо тэмдэглэсэн байна.

Судлагдан буй үед Хятадын өргөн зах хязгаарт болж байсан үйл явдлууд нь үндэстний асуудлын роль, түүний байр суурийн асуудалд Хятадын улс төрийн зүтгэлтнүүд хайнга хандаж, түүнийг ердөө «хил хязгаарын асуудал» мэтээр үзэж байсан байна. Энэ үед тус оронд үндэстнүүдийн зөрчил дээд цэгтээ хүртэл хурцдан гол төлөв хятад үндэстэн ноёрхон, хятад биш үндэстнүүд дарлагдсаар иржээ.

Өөрөөр хэлбэл, зохиогчид уг номондоо Хятадын Синьхайн хувьсгалаас 1949 оны 10-р сард БНХАУ байгуулагдах хүртэлх үеийн Хятад дахь үндэстний асуудалд дүн шинжилгээ хийж, гоминданы үндэстний бодлогын онол, практикийн тухайн үеийн байдлыг задлан шинжилж, энэ үеийн үндэстний асуудлаархи ХКН-ын бодлого, Хятадын үндэстний томоохон районуудын судлагдаж буй үеийн дотоод улс төрийн байдал, үндэстний эрх чөлөөний хөдөлгөөний шинж байдлыг тодорхой харуулжээ. Тухайн түүхийн үе тус бүрээр хятад биш үндэстнүүд оршин суудаг районууд—Синьцзян, Өвөр Монгол, Төвд, Хята-

*В. А. Богословский, А. А. Москалев. Национальный вопрос в Китае. (1911-1949), М., 1984.

дын Өмнөд, Баруун Өмнөд хэсэг дахь үндэстний районуудын байдлыг он цагийн дэс дарааллын дагуу өгүүлсэн ажээ. Уг номын нэгдүгээр бүлэг нь Синьхайн хувьсгалаас тус оронд гоминданыхан засгийн эрхийг авах хүртэлх үе (1911—1927)-ийг тусган харуулжээ. Энд Синьхайн хувьсгалын дараах Хятад дахь биш ард түмнүүд, тэд бөөгнөрөн суудаг районуудын тухайн үеийн байдалд дүн шинжилгээ хийжээ. Энэ үед тус орны нутаг дэвсгэрийн 60 орчим хувьд хятад биш ард түмнүүд амьдран, тэдний оршин суудаг нутагт хятад хүмүүс цөөн буюу бараг байгаагүйг зохиогчид тэмдэглэжээ. Нөгөө талаар Хятадын засаг захиргаа хятад биш ард түмнүүдийн эсрэг олон удаа харгислал үйлдэн, хятад үндэстэн нь хятад биш ард түмнүүдийг дарлан мөлжиж Хятадын ноёрхогчид тэднийг бүр хүний тоонд оруулан үзэхгүй байсныг тодорхой жишээгээр өгүүлжээ. Мөн 1911 оноос хойшхи Хятадын баримт бичгүүдэд Хятад дахь үндэстний асуудлыг хэрхэн тусгаж байсныг харуулсан байна.

Зохиогчид Сунь Ятсен Хятад дахь үндэстний асуудалд хэрхэн хандаж байсныг судлан үзээд тус орон дахь үндэстний асуудлаархи Сунь Ятсений үзэлд зөв зүйтэй ардчилсан чиглэл байсны зэрэгцээ тэр уг асуудад харгис, их Хятадын дээрэнгүй үзлийн хандлагаас ангижирч чадаагүй судалгааны материалын үндсэн дээр харуулсан байна. Эхний бүлгийн төгсгөлд зохиогчид Синьхайн хувьсгалын дараах Өвөр Монгол, Синьцзяны байдлыг харуулж үндэстний эдгээр район дахь үндэстний эрх чөлөөний хөдөлгөөн болон Төвд дахь тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөний өрнөлийг өгүүлсэн ажээ.

Зохиолын хоёрдугаар бүлэг нь Японы эсрэг дайн хүртэлх гоминданы ноёрхлын үе (1927—1937)-ийн Хятад дахь үндэстний асуудлыг судлахад зориулагджээ. Зохиогчид энд гоминданы баримталж байсан «нэгдмэл үндэстэн» гэдэг онолын мөн чанарыг задлан шинжлээд, энэ нь илэрхий их Хятадын дээрэнгүй үзэлд тулгуурласныг харуулжээ. Гоминданыхан Хятад дахь хятад биш ард түмнийг хан үндэстний салаа мөчир гэж үзээд, Хятадад ганцхан хятад үндэстэн (чжунхуа миньцзу) байна гэж номлодог «нэгдмэл хятад үндэстэн»-ий номлол нь Чан Кайшигийн 1943 онд хэвлүүлсэн «Хятадын хувь заяа» номонд бүрэн хэмжээгээр тусгагдсан ажээ. Гоминданыхны «нэгдмэл хятад үндэстэн»-ий номлол нь практикт Хятад дахь хятад биш ард түмний эрх ашигт шууд харшлан, уусган хятадчилах илэрхий их хятадын дээрэнгүй үзэлд тулгуурласан харгис үзэл болохоо харуулсан юм. Гоминданыхан энэ номлолдоо практикт хэрэгжүүлсэн нь хятад биш ард түмний хувьд их гай зовлон учруулсан нь түүхэнд тодорхой билээ. Чан Кайшигийн үндэстний бодлого практикт хэрхэн хэрэгжсэнийг Өвөр Монголын тухайн үеийн түүх тод харуулж байна. Өвөр Монголын зэрэгцээ Синьцзян, Төвд, Хятадын Өмнөд болон Баруун өмнөд үндэстний районуудын жишээгээр гоминданыхны харгис бодлогын дүр төрхийг харуулжээ. Тус бүлгийн төгсгөлд Хятад дахь үндэстний асуудлын талаархи ХКН-ын байр суурийг өгүүлсэн байна.

Зохиолын гуравдугаарт бүлэг нь Японы эсрэг дайны үеийн үндэстний районууд, үндэстний бодлогыг судлахад чиглэгджээ. Японы империализмын эсрэг 1937 оны зун эхэлсэн хятадын үндэстний эрх чөлөөний төлөө чухал зорилт болон тулгарчээ. Дайны эхний шатанд японы эсрэг үндэстний нэгдмэл фронт байгуулагдаж байсан нь чухал үйл явдал болсон байна. Зохиогчид энэ үеийн үндэстний бодлогын асуудал, түүнчлэн үндэстний районуудын дотоод байдлыг тал бүрээс нь судлан харуулжээ. Үндэстний районуудын зарим нь

тухайлбал, Өвөр Монгол нь Японы түрэмгийлэлд өртөж, тэнд япончууд тоглоомын засгийн газар байгуулж байсныг болон Японы түрэмгийлэгчдийн эсрэг өвөр монголчуудын явуулсан тэмцлийг харуулжээ. Японы эсрэг дайны үед Синьцзны роль их өссөн бөгөөд тулалдаж байсан Хятад орны чухал ар тал болж байжээ. ЗХУ-ын үзүүлсэн эд материалын болон зэр зэвсгийн тусламжийг тус районаар дамжуулан Хятадын төвийн районд хүргэж байжээ. Энэ бүлэгт үндэстний районуудад болж байсан тухайн үйл явдлыг район тус бүрээр задлан шинжилсэн байна.

Зохиолын дөрөвдүгээр бүлэг нь 1946 оноос 1949 оны 10-р сар хүртлэх үед Хятад дахь үндэстний асуудлыг судлахад зориулагджээ. Хятад дахь хятад биш үндэстний ард түмнүүдийн үндэстний эрх чөлөөний төлөө тэмцлийн өрнөлт нь Нанкины засгийн газрын бодлогод нөлөөлсөн, тэд хоосон хуурмаг амлалт хийх, хятад биш ард түмэнд зарим буулт хийхэд ч хүргэж байжээ. Энэ нь хятад биш ард түмний итгэлийг олох гэсэн Чан Кайшигийнхний ээлжит арга заль мэх байв. Зохиогчид энэ үеийн Хятадын үндсэн хуульд үндэстний асуудлыг хэрхэн тусгаж байсныг судлан, Өвөр Монгол дахь үндэстний эрх чөлөөний хөдөлгөөний өрнөлт, Өвөр Монголын өөртөө засах орон байгуулагдсан болон тус район дахь нийгэм—улс төрийн өөрчлөлт зэрэгтэй уншигчдыг танилцуулж байна. Тэрчлэн Синьцзян дахь хятад биш ард түмнүүдийн хувьсгалт тэмцлийн ололтууд, дэлхийн хоёрдугаар дайны дараах Төвдийн асуудлыг тусган харуулахад тус бүлэг зориулагдсан байна.

Эцэст нь тэмдэглэхэд зохиогчид Хятад дахь хятад биш ард түмнүүдийн 1911—1949 оны хоорондох түүхийг системтэй судлан, тэдгээр ард түмний тухайн үеийн түүхийн олон асуудлыг тодруулан, их Хятадын дээрэнгүй үзэлтнүүдээс тэдний талаар явуулсаар ирсэн харгис онол, практик ажиллагааг шүүмжилсэнд уг бүтээлийн ач холбогдол оршиж байна. Уг бүтээл нь Хятад дахь хятад биш ард түмний түүх, Хятад дахь үндэстний асуудлыг сонирхогч, судлагч нийт уншигчдын сонирхол татахуйц дорвитой бүтээл болжээ.

М. Хурметхан